

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛЗҮЙН ЭМГЭГ СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

Ж.САРАНЦЭЦЭГ

ЭМНЭЛЗҮЙН ЭМГЭГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Ерөнхий мэргэжлийн эмчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй;
2. Эмнэлзүйн эмгэг судлалын үндсэн мэргэшлийн резидентийн сургалтанд хамрагдсан байх;
3. Лабораторийн оношилгооны чиглэлээр 8-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл–протоколоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
5. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар, удирдамж, стандарт 3-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
8. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
9. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
10. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
11. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
12. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /холбогдох байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Ерөнхий мэргэжлийн эмчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй;

2. Эмнэлзүйн эмгэг судлалын үндсэн мэргэшлийн резидентийн сургалтанд хамрагдсан байх;
3. Лабораторийн оношилгооны чиглэлээр 13-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл–протоколоор баталгаажсан байна/;
4. Ахлах зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэжлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
6. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 4-өөс доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
8. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар удирдамж, стандарт 5-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
9. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 10-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
10. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
11. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
12. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
13. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /холбогдох байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Ерөнхий мэргэжлийн эмчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй;
2. Эмнэлзүйн эмгэг судлалын үндсэн мэргэшлийн резидентийн сургалтанд хамрагдсан байх;
3. Лабораторийн оношилгооны чиглэлээр 18-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл–протоколоор баталгаажсан байна/;
4. Тэргүүлэх зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэжлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;

6. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 5-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
8. Сүүлийн 5 жилд шинжилгээ, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт бичиг 8-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
9. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 15-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
10. Лабораторийн мэргэжилтэн бэлтгэх сургалтанд сургагч багшаар ажилласан байх /тушаал, үнэмлэх, тайлангаар баталгаажсан байна/;
11. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
12. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
13. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 8-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
14. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /холбогдох байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан байна/.